



МОНГОЛ УЛСЫН
БОЛОВСРОЛ, СОЁЛ, ШИНЖЛЭХ УХААНЫ
САЙДЫН ТУШААЛ

2004 оны 7 сарын 20 өдөр

Дугаар 240

Улаанбаатар

Гадаадад суралцуулах тухай

"Өндөр хөгжилтэй орнуудад суралцагчдын асуудлаар санал, дүгнэлт гаргах комисс"-ын 2004 оны 7 дугаар сарын 15-ны өдрийн хуралдааны тэмдэглэл, Боловсрол, соёл, шинжлэх ухааны сайд, Санхүү, эдийн засгийн сайдын 2001 оны 310/290 дугаар хамтарсан тушаалаар батлагдсан "Өндөр хөгжилтэй оронд магистрантур, аспирантур, докторантурт суралцагчдын зардлыг санхүүжүүлэх журам"-ын 2.6-г үндэслэн ТУШААХ нь:

1. Лувсансамбуу овогтой Ганзаяаг Англи улсын Манчестерийн Их сургуулийн магистрантурт эдийн засгийн чиглэлээр 1 жилийн хугацаагаар, Машбат овогтой Сэржмядагийг Австрали улсын Мельбурний их сургуулийн магистрантурт хууль зүйн чиглэлээр 1.5 жилийн хугацаагаар, Мягмар овогтой Нармандахыг АНУ-ын Де Врай их сургуулийн магистрантурт төслийн удирдлагын чиглэлээр, Мягмар овогтой Энхцэцэгийг АНУ-ын Нью-Йорк хотын Long Island их сургуулийн магистрантурт бизнесийн удирдлагын чиглэлээр, Чимиддагва овогтой Лхагвадуламыг АНУ-ын Де Врай их сургуулийн дэргэдэх Келлер удирдлагын сургуулийн магистрантурт удирдлагын чиглэлээр, Аюурзана овогтой Ариунтуяаг АНУ-ын Вашингтон хотын Стар их сургуулийн магистрантурт бизнесийн удирдлагын чиглэлээр, Эрдэнэбилэг овогтой Ариунтуяаг АНУ-ын Акрон их сургуулийн магистрантурт банкны бизнесийн удирдлагын чиглэлээр, Бадарч овогтой Баярмааг АНУ-ын Лос-Анжелес хотын Ве Угу-ийн их сургуулийн магистрантурт төрийн захиргаа, хүний нөөцийн удирдлагын чиглэлээр, Дашдорж овогтой Ганбатыг ХБНГУ-ын Дармштадт хотын Техникийн их сургуулийн магистрантурт механикийн процессийн инженерийн чиглэлээр, Цэрэн овогтой Алдармааг АНУ-ын Жонсон Вэйлс их сургуулийн магистрантурт бизнесийн удирдлагын чиглэлээр, Батбаяр овогтой Батцэцэгийг АНУ-ын Сан-Францискогийн Улсын их сургуулийн магистрантурт олон улсын харилцааны чиглэлээр, Намсрайжав овогтой Зулыг АНУ-ын Де Врай их сургуулийн магистрантурт төрийн захиргааны удирдлагын чиглэлээр, Түмэнбямба овогтой Нарантуяаг Япон улсын Токио хотын Мейжи их сургуулийн магистрантурт боловсролын удирдлагын чиглэлээр, Ганбат овогтой Батбилэгтийг АНУ-ын Өмнөд-Дакотагийн их сургуулийн магистрантурт төрийн захиргааны удирдлагын чиглэлээр тус тус 2 жилийн хугацаагаар 2004-2005 оны хичээлийн жилээс суралцуулсугай.

Сайдын 2004 оны 07 сарын 27-ны өдрийн 247 дугаар тушаалаар батлагдсан

2. Цэрэнням овогтой Батжаргалыг Итали улсын Degli Studi Di Trento их сургуулийн докторантурт, Баасанжав овогтой Сэвжидмааг ХБНГУ-ын Берлин хотын Гумболдтын их сургуулийн докторантурт, Эрдэнэбаяр овогтой Мөнхцэцэгийг Япон улсын Тотторийн их сургуулийн докторантурт, Цэрэндорж овогтой Нацагдоржийг

АНУ-ын Брандайсн их сургуулийн докторантурт тус тус 3 жилийн хугацаагаар 2004-2005 оны хичээлийн жилээс суралцуулсугай.

3. АНУ-ын Флоридагийн их сургуулийн докторантурт хэрэглээний математикийн чиглэлээр суралцаж буй Чинчулуун овогтой Алтаннар, АНУ-ын Сан-Франциско хотын Уран зургийн академийн магистрантурт суралцаж буй Онон овогтой Мичид нарын сургалтын хөтөлбөрийг харгалзан суралцах хугацааг тус тус нэг жилээр сунгасугай.

4. Батчулуун овогтой Алтанцэцэгийг АНУ-ын Вирджиниагийн их сургуулийн докторантурт эдийн засгийн чиглэлээр 3 жилийн хугацаагаар 2004-2005 оны хичээлийн жилээс суралцуулж, түүнд зөвхөн эхний жилийн сургалтын төлбөрийн зээл олгосугай.

5. ОХУ-ын Эрхүүгийн Анагаах ухааны их сургуулийн докторантурт суралцаж буй Нагний овогтой Сайжаа, ОХУ-ын Москвагийн Улсын Багшийн их сургуулийн аспирантурт суралцаж буй Баасан овогтой Оюунчимэг, ОХУ-ын Тимирязевын нэрэмжит хөдөө аж ахуйн академийн аспирантурт суралцаж буй Хулан овогтой Мягмаржав, ОХУ-ын Плехановын нэрэмжит Эдийн засгийн академийн аспирантурт суралцаж буй Ядамжав овогтой Аюушжав, ОХУ-ын Москва хот дахь Менделеевийн нэрэмжит Хими-Технологийн их сургуулийн докторантурт суралцаж буй Чимиддорж Ганзориг, Казахстан улсын Алмата хотын Эх, хүүхдийн эрүүл мэндийг хамгаалах эрдэм шинжилгээний төвийн докторантурт суралцаж буй Түдэвдорж овогтой Эрхэмбаатар нарт Сургалтын төрийн сангаас тус бүр 3000 ам.долларын хамгаалалтын зардал олгосугай.

6. Боловсрол, соёл, шинжлэх ухааны сайд, Санхүү, эдийн засгийн сайдын 2001 он.ы 310/290 дүгээр хамтарсан тушаалаар батлагдсан "Өндөр хөгжилтэй оронд магистрантур, аспирантур, докторантурт суралцагчдын зардлыг санхүүжүүлэх журам"-ын дагуу суралцагчидтай гэрээ байгуулж, холбогдох төлбөр тооцоо хийхийг Сургалтын төрийн сан /П.Лхагвасүрэн/-д, энэхүү тушаалын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Шинжлэх ухаан, технологи, дээд боловсролын бодлого, зохицуулалтын газар /М.Баасанжав/-т тус тус даалгасугай.



САЙД

А.ЦАНЖИД